




ТЭНГЭРЛИГ

МЕДИА ГРУПП

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП MSE: TNGR

ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



АГУУЛГА



| | | | |
|--|----|---|----|
| 01. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА | 02 | 03 КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН | 21 |
| 02. КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН | 06 | 04 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ | 26 |
| 2.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА | 07 | | |
| 2.2 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД | 16 | | |
| 2.3 КОМПАНИЙН БҮТЭЦ | 17 | | |
| 2.4 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ | 18 | | |
| 2.5 ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ | 20 | | |



01

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны **олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани** бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Группын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар

Охин компани: ТэнГэр ТВ, Анрид

Хараат компани: Монгол ТВ, ОриСтудиос компаниуд хамаарагдаж буй.

Нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж байгаа. Мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.



АНРИД ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Медиа, контент үйлдвэрлэл, эвент зохион байгуулах

Товч танилцуулга

Unread Media бол оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой хосолмол медиа стартап юм. Контент гэдэгт бид өгүүлэмж (storytelling), арга хэмжээ (events), коммюнити (community)-г багтаадаг бөгөөд оновчтой агуулга, урамтай хэлбэрээр хэрэглэгчдийг гүнзгий суралцахад, далайцтай сэтгэхэд, илүүг бүтээхэд замчлах нь бидний чин эрмэлзэл.

Хүний тоо

15+



ПРО МЕДИА НЕТВОРК ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Бизнес мэдээ, контент үйлдвэрлэл, шууд эфир

Товч танилцуулга

Монголын телевизийн салбарыг бизнес төвтэй мэдээ, түншлэл хамтын ажиллагаа суурьтай контентуудаар өнгөлөх гэж буй хуучнаар "VTV" буюу одоо "ТэнГэрТВ". Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд анхаарал хандуулан, нийгмийн тэгш байдлын төлөөх дуу хоолой болохын сацуу Монголын санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө зүтгэж, үзэгчдийн соён гэгээрүүлэх эрхэм зорилготой.

Хүний тоо

65+



МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Медиа салбарыг түүчээлэгч Монгол Телевиз

Товч танилцуулга

“Монгол ТВ” телевиз нь Монголд анх удаа оюуны өмчийн онцгой эрхтэйгээр дотоод гадаадын бүхий л контентуудыг худалдан авч, дуу дүрсний өндөр чанартайгаар үзэгчдэд хүргэхээс гадна дэлхийн томоохон шоу нэвтрүүлгийн форматаар Монголд шоу нэвтрүүлгүүдийг амжилттай бүтээж, Монголын нэвтрүүлгийн стандартад шинэчлэл хийж байна.

Хүний тоо

170+



ОРИ СТУДИОС ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Бүтээлч үйлдвэрлэл, кино контент, түрээс, эвент

Товч танилцуулга

Бид олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу дуу, дүрсний өндөр чанартайгаар бүтээж, үзэгчдэд хүргэх, Монгол соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах, уран бүтээл туурвиж, үндэсний дархлааг тогтоох зорилготой.


Хүний тоо

10+



02

**КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



01

2022 оны 02 сарын 15-ны эцнээ санал хураалтаар компанийн санхүүгийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахтай холбоотойгоор 2021 онд **Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй** тухай шийдвэрийг гаргасан.

02

ТУЗ нь 2022 оны хагас жилийн хугацаанд нийт **2 удаа** биечлэн хуралдаж, эцнээ хэлбэрээр **6 удаа** санал хураасан. Мөн компанийн Аудитын хороо; Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо; Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо нь **тус бүр 1 удаа** хуралдсан.

03

Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-аар 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн

04

TNGR, охин болон хараат компаниуд санхүүгийн тайлан (НББОУС) 27-ын дагуу **үнэн зөв илэрхийлэгдсэн** аудитын дүгнэлт авсан

05

2022/04/30-нд хувьцаа эзэмшигчдийн хурлыг **96.35%**-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулсан

06

ХЭ-ийн хурлаар **4** асуудал хэлэлцсэн бөгөөд тус бүр **96%**-с дээш зөвшөөрсөн санал авсан

2022 ОНЫ II УЛИРАЛ АНРИД



01

Таатай оффис цуврал контентийг амжилттай хэрэгжүүлж дуусгав

02

Таатай оффис цувралын үргэлжлэл “Таатай хотхон” цувралыг бэлтгэн нийтлэхээр бэлдэж буй

03

7 хоногт 2 удаа ажил карьер, амралт чөлөөт цагтай холбоотой ньюслеттер уншигчиддаа илгээдэг болов

04

Growth program-г амжилттай хэрэгжүүлэв

05


Технологийн салбарынхны хамгийн том цугларалт DevSummit 2022-г амжилттай зохион байгуулав

06

Наадмын брэндиг дээр ажиллав

07

Сангийн Яам, Khan Bank, Mobicom, Unitel, PickPack, Mongol NFT зэрэг Монголын томоохон байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна



01

7:10 мэдээллийн хөтөлбөр цацагдаж эхэлсэн


02

Цогц хөтөлбөр хэлбэрээр ажиллаж эхэлсэн

Гадаад мэдээ
Хөтөч мэдээ
Өнөөдрийн сэдэв

03

Англи хэл дээр анхны контентоо цацаж эхэлсэн
Нүүдэлчдийн түүх
Де факто тойм






04

Анхны оригинал контентуудаа хүргэлээ
Хуйвалдааны хүрд
Гэж юу вэ?



05

Төрөлжсөн мэдээллийн хөтөлбөрүүд цацагдаж эхэллээ
Энтертэйнмент мэдээ
Крипто мэдээ
Зах зээлийн мэдээ
Шинжлэх ухааны мэдээ
Технологийн мэдээ



06

Анхны асуудал хөндсөн контентуудаа цацсан
Энэ тухай
Анхаар





01

Монголын хамгийн том анхны кино болон контент үйлдвэрлэлийн цогцолбор барих барилгын тусгай зөвшөөрлөө авсан

02

Унгарын ORIGO Film Group-ийн Үйлдвэрлэл, Үйл ажиллагааны хэлтсийн дарга асан Kornel Sipos-ыг 5-р сард хүлээн авч workshop хийв

03

Kornel Sipos Ори Студиос ХХК-д зөвлөхөөр хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийн түвшинд явж байна

04

CEO Унгарын томоохон кино студи болон тоног төхөөрөмж, кино үйлдвэрлэлийн бусад тоглогч нартай уулзаж туршлага солилцсон

05


Нэмэлт хөрөнгө оруулалт татах зорилгоор биржийн бус зах зээл дээр хаалттай хүрээнд бонд гаргаж байгаа бөгөөд бондыг худалдаалах маркетингийн ажлууд хийгдсэн

06

Барилгын үндсэн хийцлэл болох ган хийц нийлүүлэгч Хятадын Duowei компанитай гэрээлэн үйлдвэрлэлийг эхлүүлж эхний хэсгийн ган хийц Монгол руу ачаалахад бэлэн болсон



02 Ардын буйдан
нэвтрүүлгийн XIV
улирлыг амжилттайгаар
дуусгав



01 The Voice of Mongolia
шоу нэвтрүүлгийн III
улирлыг амжилттайгаар
дуусгав



03 Чимгээ шоу
нэвтрүүлгийн IV
улирлыг амжилттайгаар
дуусгав



04 Сар шинийн баярын
тусгай нэвтрүүлгийг
амжилттайгаар дуусгав





06 Нүүдэл шийдэл
нэвтрүүлэг амжилттай
үргэлжилсээр байна



05 Хар хайрцаг нэвтрүүлэг
амжилттай
үргэлжилсээр байна



07 Өнөө өглөө хөтөлбөр
амжилттай
үргэлжилсээр байна




08 Оргил цаг хөтөлбөр
амжилттай
үргэлжилсээр байна



ТЕЛЕВИЗИЙН САЛБАРТ МОНГОЛ ТV



НИЙТ ҮЗЭГЧИЙН ТОО мян.хүн



ТӨРӨЛ ЖАНАР ХУВЬЧИЛСАН ТАЙЛАН




Эх сурвалж: MMCG судалгааны тайлан 2022

ТЕЛЕВИЗИЙН САЛБАРТ



Үзэгчдийн телевиз үздэг цаг



ТВ рейтинг 2021




Үзэх дуртай телевизийн нэвтрүүлэг



The Voice of Mongolia #1



Shark tank Mongolia #6



Ардын буйдан #8



Чимээгүй номын сан #22

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, %




2021/12/31

Нэгжийн
хаалтын ханш **20,000₮**

Нийт хувьцаа **6,000,000**

Нийт үнэлгээ **120 т6**




2022/06/30

Нэгжийн
хаалтын ханш **13,200₮**

Нийт хувьцаа **6,000,000**

Нийт үнэлгээ **79 т6**

КОМПАНИЙН БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Ердийн гишүүд



Г.Уянга
ТУЗ-ийн дарга
Ард Пропертиз ХХК
Гүйцэтгэх захирал




Г.Бат-Эрдэнэ
Тэнгэрлиг Медиа
Групп ХК Гүйцэтгэх
захирал



Ч.Батхүү
Брикланд ХХК
Гүйцэтгэх захирал



Б.Золбоо
Ард Санхүүгийн
Нэгдэл, Санхүү
эрхэлсэн захирал



Н.Мөнхнасан
Монполимет
групп
ТУЗ-ийн дарга



А.Ундрал
ТэнГэр Телевиз,
Гүйцэтгэх захирал

Хараат бус гишүүд



В.Ганзориг
Bat Solution
Partners
УЗ-ийн дарга



Н.Цогт
Бона лекс хуулийн
товчоо, Гүйцэтгэх
захирал



Б.Наранзун
Лето Мьюзик ХХК,
Гүйцэтгэх захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ХОРОО



Аудитын хороо



В.Ганзориг



Ч.Батхүү



Б.Наранзун

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо



Б.Наранзун



Н.Цогт



Г.Уянга

Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо



Б.Золбоо



Н.Мөнхнасан



А.Ундрал



В.Ганзориг

УДИРДЛАГЫН БАГ



ТЭНГЭРЛИГ МЕДИА
ГРУПП

TNGR:
Гүйцэтгэх захирал



Г.Бат-Эрдэнэ


TNGR: Санхүү эрхэлсэн
захирал



Д.Бат-Оюун

ОХИН КОМПАНИЙН
УДИРДЛАГА

TenGer TV: Гүйцэтгэх
захирал



А.Ундрал

Unread: Гүйцэтгэх
захирал



Д.Ганзориг



03

**КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН сая.төг



| ҮЗҮҮЛЭЛТ | ГРУПП | ТОЛГОЙ КОМПАНИ |
|---|---------------|----------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 64 | 4 |
| Дансны авлага болон бусад авлага | 2,897 | 2,498 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 313 | 34 |
| Үндсэн хөрөнгө | 2,409 | 10 |
| Биет бус хөрөнгө | 847 | - |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 14,381 | 13,881 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 1,215 | 1,215 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 22,126 | 17,642 |
| Дансны өглөг болон бусад өр төлбөр | 3,336 | 383 |
| Богино хугацаат зээл болон хүүгийн өр төлбөр | 363 | 363 |
| Урт хугацаат зээл | 3,130 | 1,167 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 1,506 | 2,340 |
| ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 8,336 | 4,253 |
| Энгийн хувьцаа | 822 | 599 |
| Нэмж төлөгдсөн капитал | 13,249 | 12,352 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 287 | - |
| Бусад дэлгэрэнгүй орлого. | 308 | 308 |
| Хуримтлагдсан ашиг | (877) | 129 |
| ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН | 13,791 | 13,389 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН | 22,126 | 17,642 |

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН **сая.төг**



| ҮЗҮҮЛЭЛТ | ГРУПП | ТОЛГОЙ КОМПАНИ |
|--|----------------|----------------|
| Борлуулалтын орлого | 1,222 | - |
| Борлуулалтын өртөг | (402) | - |
| НИЙТ АШГИЙН ДҮН | 820 | - |
| Хүүгийн орлого | - | 74 |
| Бусад орлого | 0 | 0 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (2,062) | (202) |
| Борлуулалт, маркетингийн зардал | (24) | (15) |
| Санхүүгийн зардал | (64) | (139) |
| Бусад зардал | (3) | (0) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 0 | 0 |
| ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ) | (1,333) | (281) |
| Татварын зардал | (8) | - |
| ТАТВАР ТӨЛСНИЙ ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ) | (1,340) | (281) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 308 | 308 |
| НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ДҮН | (1,032) | 27 |

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН сая.төг




| ҮЗҮҮЛЭЛТ | ГРУПП | ТОЛГОЙ КОМПАНИ |
|---|--------|----------------|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (169) | (143) |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (922) | (1059) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (65) | (15) |
| Цэвэр мөнгөн гүйлгээ | (1157) | (1217) |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1221 | 1221 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 64 | 4 |


САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД TNGR сая.төг




ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ сая.төг




НИЙТ ХӨРӨНГӨ сая.төг




НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ сая.төг




НИЙТ ӨР ТӨЛБӨР сая.төг



ХУРИМТЛАГДСАН АШИГ сая.төг



БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО сая.төг





04

**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
ҮНЭЛГЭЭ**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ



| TNGR | ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК - ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ | Оноо | Хувь |
|--------------------|--|-----------|--------------|
| № | КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН 9 ЗАРЧИМ | 72 | 100% |
| НЭГ | ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОНБАЙГУУЛАЛТ- 12 | | |
| | ТУЗ нь олон талт үр чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна | 12 | 16.7% |
| ХОЁР | ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ-10 | | |
| | ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ | 10 | 13.9% |
| ГУРАВ | ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ-6 | | |
| | ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана | 6 | 8.3% |
| ДӨРӨВ | АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО-6 | | |
| | ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана | 5 | 6.9% |
| ТАВ | ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА-8 | | |
| | ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина | 7 | 9.7% |
| ЗУРГАА | ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ-6 | | |
| | Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна | 4 | 5.6% |
| ДОЛОО | ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ-8 | | |
| | Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ | 6 | 8.3% |
| НАЙМ | КОМПАНИЙН СОЁЛ-6 | | |
| | ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно | 5 | 6.9% |
| ЕС | ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ-10 | | |
| | Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана | 10 | 13.9% |
| НЭГДСЭН ДҮН | | 65 | 90.3% |

Авбал зохих нийт оноо 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал **хэвийн буюу эрсдэлгүй**

Өөрчлөлт оруулах, шинээр батлах шаардлагатай журмууд:

- ТУЗ-ийн ёс зүйн кодексийг шинэчлэх
- Комплайнсын хяналтын журам
- Цалин урамшууллын журмыг шинэчлэх
- Дотоод аудитын журам
- Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичгийг шинээр батлах



ТЭНГЭРЛИГ

МЕДИА ГРУПП

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Удвал

